

УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛЭЭР СУРАГЧДЫН ХОШИН ШОГИЙН МЭДРЭМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Ц. Март *

Ер нь хүнд хошин шогийн мэдрэмж байх ёстой юу? гэсэн асуултад хүн бүр өөрийнхөөрөө л хариулна. Хошигноно, хошигнолыг хүлээн авна гэдэг нь хошин шогийн мэдрэмжтэй байгаагийн илрэл. Ямар нэг зүйлээс инээдтэй зүйлийг олж хараад инээх нэг хэрэг. Инээдтэй зүйлийг яриад эсвэл зохиогоод бусдыг инээлгэх бүр нарийн хэрэг. Хошин шог зохиолыг заах, хошигнолыг ойлгуулах нь багшаас ихээхэн ур чадвар шаардана.

Дунд сургуулийн суурь боловсролын хөтөлбөрийн 7-р ангид Ишданзанваанжилын “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал” сургаалын зохиол, Д.Цэвэгмидийн “Алагдай аварга” найраглал, Ж.Барамсайн “Цүнхтэй инээд” өгүүллэг, ахлах боловсролын цөм хөтөлбөрт Д.Нацагдоржийн “Ламбугуйн нулимс” зэрэг хошигнол агуулсан зохиолууд, 8-р ангид Ч.Ойдовын “Далан худалч” хошин жүжгийн уншуулахаар хэрэглэгдэхүүн болгож оруулсан байгаа.

Юуны өмнө хошин зохиол, шог зохиол хоёрын мөн чанарыг ялгаж чаддаг байх нь чухал юм. Хошин буюу инээдэмт зохиол нь нөхөрсөг зөөлөн байдлаар гэмгүй цагаан инээд бэлэглэхдээ ухаарал хайрлаж, сэнхрүүлж ухамсарлуулах үүргээ давхар гүйцэтгэж байдаг. Оросын зохиолч И.А.Гончаров “Шог зохиол бол ташууртай адил” гэж хэлснээс үзэхэд шог зохиол нь хайр найргүй, маш хурц шүүмжилсэн, жигших, зэвүүцэл төрүүлэх, үзэн ядалтыг бий болгох хандлага илүү давамгайл байдаг нь харагдаж байна. Дээрх хоёрын ялгааг доктор Д.Галбаатар “Хошин зохиол нь ерөнхийдөө гадаад илэрхийлэх аргаараа инээд, доог тохуу доромжлолыг бус, харин уншигчдад жогтой инээмсэглэлийг төрүүлдгээрээ онцлог” хэмээн хамгийн товчоор гаргасан байна.

Ишданзанваанжилын “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал” зохиол дахь

Ширээнд залахад гэгээн багшийн дүртэй

Шилдэг морь унах нь наймаа панзын янзтай

Шилбэлзэн загнах нь зусар золбин байдалтай

Шинэ цагийн бурхан гэдэг ийм агсан ажгуу

гэсэн бадагт шашин номын үйлээ умартаж, ёс жаягаа гажуудуулж байгаа лам нарыг шоглон шүүмжилсэн байна. Ингэж шоглохдоо егөөдлийг ашигласан бөгөөд энэ нь сурагчдын шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд нэлээд туслах юм.

* Нийслэлийн ерөнхий боловсролын 11-р сургууль

Хошин шогийн мэдрэмжийг төлөвшүүлэх гэж ярих амархан. Үүнийг сурагчдад төлөвшүүлэхэд хошигнол бүтээх аргын талаар мэдэх зайлшгүй шаардлагатай. Хошин шог нь амьдралаас урган гарсан бат бөх үндэстэй, оновчтой илэрхийлсэн агуулгатай, нэн ойлгомжтой байх ёстой бөгөөд хошин шогийн мэдрэмж хөгжихийн хэрээр ухаан саруулсан цэлмэж, мэдрэмж нарийсан чамбайрч, сэтгэлгээ тэлж өргөждөг тухай ерөнхийлөгч асан Н.Багабанди “Титэм үг” номдоо дурдсан нь бий.

Үнэндээ сурагчдын унших хошин шог зохиолын тоо харьцангуй цөөн. Хөтөлбөрт оруулаад судлуулчих зохиол олоход нэлээд төвөгтэй. Учир нь зохиолчид энэ төрлөөр бичихээ бараг больсон. Хошин шогийн мэдрэмж төлөвшүүлэх үүргийг гүйцэтгэж байгаа зүйл нь хошин шогийн продакшнуудын тоглолтууд. Мөн түүнээс гадна өөрсдийн нас сэтгэхүйн онцлогтоо тохироогүй онигоо ярих эсвэл “Facebook”-ээр аялж хөгжилтэй хошин зүйл харж инээлдэх...

Энэ өгүүлэлдээ 8-р ангид судлуулахаар сонгосон Ч.Ойдовын “Далан худалч” хошин жүжгийг жишээлэн хошигнол бүтээх аргыг хэрхэн хэрэглэсэн талаар авч үзье.

Хошин жүжиг нь өөрөө нийгэм, хүмүүсийн аж төрөл, ажил үйлс, зан суртахуун, харилцаанаас үүсэлтэй, шүүмжлэлт агуулга, хөгжилтэй хошин өгүүлэмж бүхий жүжгийн нэг төрөл зүйл байдаг¹.

Хошигнол бүтээх аргын талаар Г.Нандинбилиг “Монгол ардын шог хошин үлгэрийн хошигнол бүтээх аргууд”, “Ри багшийн түншүүр хууч ярианы хүүрнэл дэх хошигнол бүтээх аргууд” зэрэг бүтээлдээ авч үзсэн бөгөөд тэрбээр

- Зан төрхийн хошигнол
- Учир шалтгааны хошигнол
- Нөхцөл байдлын хошигнол
- Үг хэлний хошигнол
- Дохио зангааны хошигнол гэж задалж тайлбарласан байна. Хошигнолын дээрх хэлбэрүүд “Далан худалч” жүжигт хэрхэн илэрснийг авч үзье.

Далан худалч жүжиг дэх дүрүүдийг авч үзвэл эерэг гол дүр Сэнгээг дагасан эерэг зан төрх бүхий Давст буюу Дамдин, Бат, Тунгалаг, Алимаа, Гэлэг нар, сөрөг зан төрх бүхий дүр Баян, Галдан, Жалбуу, Далай буюу хятад, Пагма авгай зэрэг дүрийн систем байна. Зохиолд өрнөж байгаа үйл явдлыг холбогч хүч нь Сэнгээ буюу далан худалч байна.

Нийгмийн байдал руу чиглэсэн, тухайн цаг үе болоод баяд ноёдыг шүүмжилсэн бадарчны сэдэв, Бэлэн Сэнгэ, Далан худалчийн хошин ярианы сэдэв, өгүүлэмж дээр тулгуурласан энэ жүжигт нэлээд тод томруун илэрч байгаа хошигнол нь зан төрхийн хошигнол байна. Зан төрхийн хошигнолыг хэрхэн гаргасныг доорх байдлаар авч үзэж болох юм. Далан худалч жүжиг хоч нэрээр баялаг. Ялангуяа жүжгийн гол дүр Сэнгээ. Олонд алдаршсан нэр нь “Далан худалч”. Далан гэдэг үг өөрөө олны утга илэрхийлдэг. Тухайлбал:

- **Далан давхар**- а. Олон давхар, б олон үетэй бин буюу гамбир
 - **Далан долоон үг дэлгэх**- дэмий юм чалчих
 - **Далан нөхөөс**- энд тэндгүй нөхөж оёсон уранхай цоорхой байдал
 - **Далан таваар бууж өгөх**- ялагдаж дийлэгдсэнээ хүлээн зөвшөөрөх
- Далан хэлийн амьтан**- газар газрын олон хүн гэх мэт.

¹ Галбаатар Д (2012), Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл, Улаанбаатар, 472-р тал.

Хоч нэрийн талаар эрдэмтэд өөр өөрийн саналаа дэвшүүлсэн нь бий. Тухайлбал: Доктор Д.Бадамдорж “Хоч нэр гэж тухайн хүний зан чанар, өнгө зүс, дадал зуршлаас улбаалсан, ёжилсон утгатай олдмол нэрийг хэлнэ” гэсэн бол доктор Д.Энхбат “Хоч нэр бол хүний зан чанар, араншин, царай зүс, биеийн хэлбэр, дадал зуршлаас үүдэн нэрлэсэн, бусдаас онцгойлон ялгасан нэр юм” гэж тодорхойлсон нь бий. Судлаач Н.Нансалмаа “Хоч нэр нь нэг талаас нэг хүн зохиодог тохиолдлын шинжтэй мэт боловч нөгөө талаас нэг удаа хэрэглээд мартагдахгүй, харин урт удаан хугацааны амьдралтай байгаа нь нийгмийн хамт олон энэ хоч нэрийг хүлээн зөвшөөрч урт хугацааны эргэлтэд оруулдагтай холбоотой. Иймээс хоч нэр үүсэхдээ хувь хүний шинжтэй боловч хэрэглээний явцад нийгмийн шинжтэй болдог”² гэж хоч нэрийг нийгмийн шинж талаас нь тайлбарласан бол эрдэмтэн Б.Пүрэв-Очир нийгэм хэл-шинжлэлийн талаас авч үзсэн нь байна.

Далан худалч гэсэн хоч нь Ж.Бат-Ирээдүйнхээр “Зан чанар, араншингаар”-нь, судлаач Д.Бадамдоржийн тодорхойлсноор “Зан чанар, дадал зуршлаар” нь, эрдэмтэн Нансалмаагийнхаар “тухайн хүний зан ааш, дотоод ертөнцтэй холбоотой”-оор өгсөн нэр болж таарч байна. Маш их худлаа ярьдаг хүн гэсэн утга бүхий “Далан худалч” гэдэг нь Сэнгээгийн хоч нэр. “Бэлэн” гэдэг хочийг тайлбарлавал түүний хэлэх шоглох үг нь ямагт бэлэн бөгөөд өрсөлдөгч этгээдийг давах гол хэрэгсэл нь болж өгдгөөс үүдсэн нэр болов уу гэж үзэж байна.

Жүжгийн нэгдүгээр үзэгдэлд “Хувилгаан багшийгаа хувалз гэсэн, хошуу ноёныгоо бирд гэсэн Майрамд Маарай гэгдэх майжгий Лувсан, Сайрамд Сарай гэгдэх сайжгий Самбууг барьж өгсөн хүнд нэг зуун тавин лан мөнгө шагнана”³ гэж дүрсэлсэн байдаг. Эдгээр хоч нэрийг харахад Майрамд Маарай, Сайрамд Сарай гэсэн нэрс нь ямар нэгэн утга илэрхийлэхгүй бөгөөд майжгий, сайжгий гэсэн хоёр үгтэй толгой холбож, авиа ижилсүүлэн хошигнол бүтээсэн байна.

Мөн түүнчлэн эерэг гол дүр болох Сэнгээг дагасан эерэг зан төрхтэй хүн бол Дамдин. Түүний хийдэг ажил, амьдралаа залгуулдаг гол үйл нь давс зарж наймаа хийх явдал. Өөрөөр хэлбэл эрхэлж буй ажил төрлөөрөө тэр олон түмэнд Давст гэж нэрлэгдсэн хүн. Дамдин аа! гэж дуудахаас илүү Давст аа! гэж дуудах нь түүнд илүү дотно болсон гэж дүгнэж болох юм.

Зан төрхийн хошигнолыг бүтээхэд үг хэлний хошигнол түлхүү үүрэгтэй бөгөөд энэ нь уран дүрслэлийн утга шилжүүлэх арга болох егөөдөл, ёгтлол, хэтрүүлэл хэрэглэж байгаагаар илэрдэг. Жүжгийн өгүүлэмжид энэ бүхэн хэрхэн илэрснийг авч үзье.

Егөөдөл: Егөөдлийн тухай доктор Д.Галбаатар “Юмс үзэгдлийн гол мөн чанар, аль нэг шинжийг шууд утгаар бус, харин эсрэг утга болон сөргүүлж гаргах, тэдгээрийн хооронд агуулагдах зөрчлийн эрчмийг ихэсгэх, уран сайхны шоглолын арга”⁴ гэж тодорхойлсон нь бий. Зан төрхийн хошигнолыг илрүүлэхэд егөөдөл нэлээд үүрэгтэй. Тухайлбал хайртай бүсгүйтэйгээ гэрлэж чадаагүй Далай нэрт хятад, өргөмөл охин Алимаагаа хятадад худалдах башир аргаа хэрэгжүүлж чадаагүй Пагма авгай хоёрын хувьд байдал нэлээд хүнд болдог. Энэ үед Сэнгээ “Ганц мод гал болдоггүй, ганц хүн айл болдоггүй. Чи Пагмыг аваад яв. Замаасаа ганц илжиг худалдаж аваад явж Пагмаатай явж байхад та хоёрыг хэн ч сэжиглэхгүй. Нэг ядарсан луухаан авгайтайгаа явж байна

² Нансалмаа Н (2009), Үг, утга, хэрэглээ, Улаанбаатар, 44-р тал.

³ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол, Улаанбаатар, 213-р тал.

⁴ Галбаатар Д (2012), Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл, Улаанбаатар, 142-р тал.

гээд л явуулаад байна”⁵ гэж хэлдэг. Энэ нь наанаа ерөвдсөн мэт царай гаргаж, эрсдэлтэй байдлаас зайлуулж байгаа мэт боловч цаанаа бол доромжилж, түмний элэг доог болох замыг нь зааж өгч байна.

Мөн түүнчлэн гишгэх газаргүй болж, хэрэгт ороолцолдсон Галдангийн жинстэй малгайг нь авч муу малгайгаа өгөөд “Одоо наадах чинь дөнгө болно. Үүнийг өмс”⁶ гэж хэлдэг. Үнэндээ бол Галданг хэргээс мултлах арга зааж өгч байгаа төдий биш ард түмний энх амьдрал ойртож, баяд ноёдын мөхөх цаг ирж байгааг егөөдөн хэлжээ.

Ёгтлол: Ёгтлол гэж аль нэг талаараа төсөө бүхий юм үзэгдлийг өөр үгээр орлуулж, үндсэн санаагаа далдуур, бүхэл цогц утгыг уран сайхны аргаар гаргасныг хэлдэг.⁷ Ёгтлол хэрэглэсэн жишээг энэ жүжгээс харж болно. Тухайлбал: Жирэмсэн байх үед нь гэрлэх гэж байсан эмэгтэйд хаяж явчихаад хүүгээ төрснийх нь дараа авах гэж улайрч байгаа Галданд Сэнгээ ийн хэлдэг. “...Манайх нэг сайхан бухтай юм. Тэгээд түүнийгээ ноднин хавраас эхэлж алдчихаад эрээд олдоггүй байлаа. Тэгсэн чинь ноднин хавар, зуны турш энэ хүрээний ойр хавийн ноёд баядын олон үхэрт нийлчхээд олдоггүй байсан юмсанжээ. Тэгсэн чинь одоо энэ жил болоод ирэхтэй зэрэг тэр олон айлуудаар ч нэг манай бухны тугал байна...Тэд чинь миний тугал мөн биз дээ” гэж хэлэхэд Галдан: “Чи тэр тугалнуудыг л яасан ч авч болохгүй” гэж хэлдэг. Тэгэхэд нь Сэнгээ: “Энэ эмэгтэй хүүхдээ яах вэ? Хаяад явсан эцэгт нь өгөх үү?”⁸ гэж асууснаар Галдан хэлэх үггүй болж, эмэгтэй ч хүүхдээ авч үлддэг. Ухамсарт хүний ухамсаргүй үйлдлийг адгуусны үйлдэлтэй жишин ёгтолсон нь оновчтой болжээ.

Мөн “Майрамд Маарай, Майжгий Лувсан ... гээд нэр чинь таны нэрүүд үү? яасан олон нэр вэ?” гэж Давстын гайхашран асуусан асуултад Сэнгээ: “Юу нь олон байх вэ дээ. Малын нэг баас хүртэл олон нэртэй байхад хүний хүү надад энэ зэрэг нэр олон бишээ... Малын баас чинь өтгөн гарвал нэг янз, шингэн гарвал нэг янз, хатуугаараа аргал, түлэхээрээ түлээ, түлэгдсэн хойноо үнс”⁹ гэж хэлээд аргалын дулаан элчтэй өөрийн тустай үйлийг адилтган өгүүлж, зэрэгцүүлэн жишиж байна. Энэ бол ёгтлолын жишээ.

Хэтрүүлэл: Хэтрүүлэн багасгах, хэтрүүлэн ихэсгэх уран дүрслэлийн арга нь монгол ардын үлгэр дэх хошигнол бүтээх нэг арга. Энэ жүжгийн үзэгдэл бүрд хэтрүүлэл хэрэглэсэн жишээ нэлээдгүй. Далан худалчийн давагдашгүй гэдгийг “Багш ламтан сор залахдаа Далан худалчийг барьж авах их даатгал хийлгэсэн гэнэ”¹⁰ гэсэн Жалбуугийн үг, бурхан зарж явдаг төвд хүнийг Далан худалч гэж андуураад ташуураар цохиж алсан Галдан, Жалбуу хоёрын “Сэнгээг алах бол буян”¹¹ хэмээн сайрхаж байгаа үг зэргээс тод харж болно. Сор залах үйл нь өвлийн улирлын сүүл сард тэрс номтны ёс, шашин лугаа дайсагнагчидтай тэмцэн няцаагч догшидыг магтах үйл байдаг бөгөөд тарнийн хүчээр муу муухайг шингээж, цамын үед галд хаяж устган, муу муухайгаас салж буй санааг илэрхийлдэг шашны үйл байдаг байна. Шашны зан үйл хүртэл дан ганц Далан худалчтай тэмцэх үйл байсан гэдэг нь хэтрүүлэл юм. Ингэж хэтрүүлэхдээ Галдан, Жалбуу нарын дэгс яриатай, юмны хүчийг нэмэгдүүлэн давсалж ярьдаг чанарыг нь тод

⁵ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол. Улаанбаатар, 261-р тал.

⁶ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол. Улаанбаатар, 260-р тал.

⁷ Галбаатар Д (2012), Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл, Улаанбаатар, 145-р тал.

⁸ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол. Улаанбаатар, 217-р тал.

⁹ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол. Улаанбаатар, 221-р тал.

¹⁰ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол. Улаанбаатар, 212-р тал.

¹¹ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол. Улаанбаатар, 243-р тал.

гаргажээ. Уншигч түмэн Алимаагийн хувцсыг өмсөөд нүүрээ даран уйлж суугаа Далан худалчийн үйлдлийг уншаад, *“Харин ч улам том болчихсон юм шиг”* хэмээн итгэлтэй хэлж байгаа Пагмын үгийг сонсоод *“Ийм юм гэж байх уу? гээд эргэлзэх юмуу үгүйсгэж болно. Үүнийг уншаад инээж байгаа нь хэтрүүлэл хэрэглэсний үр дүн юм. Инээдэмт зүйл нь тухайн хүний санамсаргүй үйлдлээс үүсдгийн жишээ нь энэ. Аливаа зүйлийг мэдэхгүй чадахгүй юмуу, эсвэл бүдүүн баргаасаа, анзааргагүй байдлаасаа болж инээдэмт байдалд орж байгаа нь /Жалбуугийн цуу үгэнд итгэж, Пагма бодож төлөвлөсөн зүйлээ ёсоор болно гэдэгт найдаж байгаагаасаа зэрэг нь /уншигчдад сургамжтай бөгөөд ухаарал хайрласан дүрслэл болж байна.*

Мэргэн цэцэн үг: Оновчтой мэргэн цэцэн үг хэллэг инээдмийн зохиолд онцгой ач холбогдолтой.¹² Ийм үг хэллэгийн жишээг дурдъя. Давстаас давс авахдаа Батын *“Давс амттай гэвч дангаар идэж болохгүй, чихэр амттай гэвч жингээр идэж болохгүй”* гэж хэлсэн үг, Сэнгээгийн *“Чи ер нь мөнгөөр юм бүрийг, хүний сэтгэл санааг хүртэл худалдаж авч болно” гэж боддог байх шүү*” гэж Далай буюу хятдад хорсон хэлсэн, *“Далан худалч нь одоо ирсэн замаараа сурсан дуугаа дуулаад ноёны нэрийг ном болтол, нохойн толгойг ноос болтол явъя”* гэж хийсэн үйл хэрэгтээ сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн, *“Бирдийн нүдэнд далай харам”* гэж гуйлга гуйхдаа хэлсэн үгс, *“Ядарсан надад Пагмаа ч яах вэ?”* гэж Хятдын аргаа барахдаа хэлсэн үг зэрэг нь жүжгийн дүрийг тодотгох, үйл явдлыг хурцатгахад чамбай дүрслэл болжээ. *“Ядарсан надад Пагмаа ч яах вэ?”* гэсэн Далай хятдын үгээс *“Лам олдохгүй бол буцахдаа зална”, “Шилсэн юм шил дарж, голсон юм голд орно”* зүйр үгийн санаа харагдаж байна.

Нөхцөл байдлын хошигнол: Нөхцөл байдлын хошигнол бол хүмүүсийн үл ойлголцол хийгээд муу ая занд тулгуурлаж, голдуу зохиогчийн дүрслэн бодож олсон сэдэл хатгаасын дундах нөхцөл байдлыг үүсгэх замаар хошигнох арга маяг юм.¹³ Энэ жүжгээс нөхцөл байдлын хошигнол бүхий жишээг ав үзье. Ард түмэнд туслах хүслийг ямагт өвөрлөн явдаг Далан худалч боломжийг хэрхэн ашиглах, нөхцөл бололцоог ядарсан түмэнд ашигтайгаар хэрхэн эргүүлэх талаар нэлээдгүй зүйлийг хийдэг гүйлгээ ухаан сайтай нэгэн. Тухайлбал: Жалбуу, Галдан нар Сэнгээг бариад *“Чи тийм айхамтар худалч юм бол биднийг энэ хаалгаар ортол худал хэлээдэх”* гэж хэлдэг. Хариуд нь Сэнгээ: *“Одоо ч би та нарын гарт оржээ. Харин та нарыг хаалгаар орчихвол гарч иртэл чинь худал хэлж чадна даа”*¹⁴ гээд мэхэлж чаддаг. Ийм өгүүлэмж *“Далан худалч даншгийн наадамд очоод дархан цолоор шагнуулав”* үлгэрт байдаг. Далан худалч Түшээ гүн ноёнтонд бараалхан эрт дээр үед залуу байх үед зээлүүлсэн алтаа авах тухай хэлэхэд ноёнтон худал хэлж байна гээд хүлээн зөвшөөрдөггүй. Тэгээд *“Чи муу хөсрий өвгөн үнэхээр худалч юм бол гэрээс гартал худал хэлээд орхи”* гэхэд Далан худалч: *Би таныг гэрээс гартал худал хэлж чадахгүй, харин гаднаас ортол чинь худал хэлж чадна”* гэж хэлэхэд *“За тэгвэл би гадаа гараад зогсож байя. Чи худлаа хэлээд орхи”* гээд алив түргэлээрэй” гэж хашгиран гадаа гараад зогсдог. Харин Далан

¹² Цэнд-Аюуш Ш, Уран дүрийн үг, Улаанбаатар, 54-р тал.

¹³ Нандинбилиг Г (2015), Монгол ардын үлгэрийн хошигнол бүтээх аргууд”. Mongolia: Area and cultural studies, Vol 3 (421), The institute for Mongolian Studies. NUM, Улаанбаатар, 173-р тал.

¹⁴ Ойдов Ч (1974)Түүвэр зохиол. Улаанбаатар, 227-р тал.

худалч” Би аль хэдийн таны урьд хэлсэн ёсоор гэрээс чинь гартал худлаа хэлж амжсан шүү”¹⁵ гэхэд ноён ялагдсандаа уурладаг.

Жүжгийн нэгдүгээр бүлгийн нэгдүгээр үзэгдэлд давсаа асгачхаад салгалсан үхээр гэж уулгалсан Давстын үгийг согтуу баян овжин ашиглаж “Намайг дайруулаад хүрэн амбаныг хүртэл харааж байна. Салга хүн хүрээнд амбан бид хоёр доо. Өөр байхгүй. Бид хоёр л салгалсан үхээр болж дээ”¹⁶ гээд гурван тэмээгээр торгохоос нааш миний гомдол тасрахгүй ээ хэмээн нэхэл хатуутай загнадаг. Галдан, Намнан хоёр ч салга баянтай хуйвалдаж Сэнгээд энэ тухай хэлэхэд Сэнгээ” Тэнд чинь бас миний гурван тэмээ бий. Харин цагаан халзан биш, улаан халзан. Багш ламтан минь зүс нийлүүлж авсан хайртай тэмээнүүд байгаа юм”¹⁷ гэж хэлээд цагаан халзан бишээ, улаан халзан гэж хашгирдаг. Сэнгээгийн энэ үгийг Бат овжин тусгаж цагаан халзан тэмээг улаан болгож Давстыг гүтгэлгээс аварч, дээрээс нь улаан халзан гурван тэмээтэй болдог. Сэнгээ, Бат хоёрын хуйвалдааны хошигнолыг илрүүлэх хэлбэр болох гэнэтийн үйлдэл, гайхшруулал /Surprise/ гэж үзмээр. Нөгөө талаар учир утгагүй юм /Incongruity/ гэж анзаармаар. Үнэндээ амьдрал дээр тэмээний өөрийн зүс, зориудаар өөрчилсөн тэмээний зүс хоёрыг ялгахгүй хэн байх билээ.

Мөн түүнчлэн Алимаа бүсгүйтэй хуйвалдан Пагма авгайн бурхны ширээн доогуур орж, ухаан чөлөөгүй мөргөж байгаа Пагма авгай, Далай хятад хоёрын сүсэглэлийн хариуд “Зуны дунд сарын шинийн таванд олдошгүй сайн өдөр байна. Хүрээнд биш, хөдөө гэртээ гэрлүүлбэл буян хишиг, өлзий хутаг оршино”.¹⁸ хэмээн хэвнэг хариулж байна. Үүнээс үзэхэд Сэнгээгийн гүйлгээ ухаан, уран арга нь инээдэм төрүүлэхээсээ илүү түүний башир аргад итгэж байгаа Галдан, Намнан, Баян, Далай /хятад/, Пагма нарын үйлдэл нь илүү инээдэмт байдалд хүргэж байна.

Амьдралд инээдэмт зүйл нь хошигнолыг бий болгож, хошигнол нь эргээд инээдмийг үүсгэдэг, нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлсэн ойлголт юмуу гэж ойлгож болмоор санагдана. Судлаач А.Натев инээдмийг

- Амьд зүйлийн схемчлэл, нарийн төвөгтэй зүйлийн схемчлэл
- Үйл явдлын гэнэтийн эргэлт, өөрчлөлт
- Учир шалтгаант байдлыг утга учиргүй мэт харуулах
- Жижиг зүйлийг чухал, ялимгүй юмыг чухал мэт харагдуулах
- Хүчтэй зүйлийн гэнэтийн буурал, сул дорой дахь гэнэтийн хүч чадал
- Үнэн бодит байдлыг гажуудуулах
- Хоцрогдсон зүйлээс үүдэх инээдэм
- Шинэ зүйлээс үүсэх инээдэм гэж ангилжээ.¹⁹ Энэ ангиллаас харахад Ч.Ойдовын

“Далан худалч” жүжиг нь үйл явдлын гэнэтийн эргэлт өөрчлөлт /цагаан халзан тэмээг улаан халзан болгох, Сэнгээгийн бурхны ширээн доогуур орж амилсан бурхан болох зэрэг/, жижиг зүйлийг чухал, ялимгүй юмыг чухал мэт харагдуулах /“Мөнгөөр юм бүрийг, хүний сэтгэл санааг хүртэл худалдаж авч болно. Энэ бол ялимгүй зүйл” гэж бодож байгаа Хятадыг чадсан/, хүчтэй зүйлийн гэнэтийн буурал, сул дорой дахь гэнэтийн хүч чадал / ноёд баячуудын бүхнийг ялан дийлэх гэсэн үйлдэл нь мөхөж, ард

¹⁵ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол. Улаанбаатар, 378-р тал.

¹⁶ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол. Улаанбаатар, 219-р тал.

¹⁷ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол. Улаанбаатар, 219-р тал.

¹⁸ Ойдов Ч (1974), Түүвэр зохиол. Улаанбаатар, 234-р тал.

¹⁹ Галбаатар Д (2012), Уран зохиол: Онол түүх, шүүмжлэл. Улаанбаатар, 199-р тал.

түмний эрх чөлөөгөө мэдэрч байгаа үйл явдал, /хоцрогдсон зүйлээс инээдэм үүсэх /сор залах ёслол хүртэл Далан худалчийг үгүй хийхэд зориулагдсан/ гэх мэтийн инээдмийн баримтаар дүүрэн байна.

Монгол ардын үлгэр туулийн гол дүр нь өнчин хүү байдаг бөгөөд тэр нь арга ухаантай, билэг эрдэм төгс, эр зоригтой, хүний зан чанарын эрхэм сайхныг шингээсэн нэг нь байдаг. “Далан худалч” жүжгийн гол дүр Сэнгээ ч өнчин хүү. Энэ нь “Сэнгээд хүн сайн байж болохгүй. Тэр чинь гэр оронгүй өнчин хүн. Хүрээнд сууж байхдаа хамгийн эрдэмтэй шавь байсан юм. Тэгээд багш ламтан хайртай, эрх дураар нь тавьдаг байсан юм. Заяагүй юм чинь яах вэ? тэгээд зугтсан даа”²⁰ гэж хэлсэн Жалбуугийн үгнээс илэрч гардаг. Үүнээс үзэхэд Сэнгээгийн дүр нь ардын үлгэр туульсад гардаг өнчин хүүгийн уламжлалт дүр болох нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

1. Далан худалч жүжигт хошигнол бүтээсэн аргыг харахад зан төрхийн хошигнол, нөхцөл байдлын хошигнол бүтээх аргууд нэлээд зонхилж байна. Хошигнол бүтээх дээрх хоёр аргыг үг хэлний хошигнол нь илүү тодотгож өгч байна.

2. Нийгэм ард түмний амьдралд байгаа инээдэмт зүйлийг өлгөн авч хошигнон илэрхийлсэн нь эргээд бусдад инээд хайрлаж байгаа нь инээдэмт зүйл хошигнол хоёр нь нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлсэн ойлголт байдгийн илэрхийлэл болж байна.

3. Дүрийн зан төрхийн хошигнолыг бүтээхэд хоч нэр ихээхэн үүрэгтэй байгаа нь энэ жүжгийн Сэнгээгийн дүрээс харагдаж байна. Бусдын төлөө хууран мэхэлж, худал хэлж, арга ухаанаа уралдуулж байгаа нь түүний зан төрхийн шууд тусгал болсон хоч нэрийг авчирчээ гэж болох юм.

4. Ёгтлол, егөөдөл, хэтрүүлэл зэрэг уран дүрслэлийн утга шилжүүлэх аргууд нь дүрийн зан төрхийг тодруулахад чухал хэрэглэгдэхүүн болж чаджээ.

5. Мэргэн цэцэн үг хэллэг нь хошигнол бүтээх, гол ба туслах дүрийн зан төрхийг тодруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг нь харагдаж байна.

6. Хошин шогийн мэдрэмж төлөвшүүлэхдээ тухайн уншиж байгаа зохиолоос инээд хүргэж байгаа зүйлсийг ялгаж бичүүлэх буюу яриулах нь чухал.

7. Хошигнол бүтээх аргаас суралцсанаар сурагчид өөрийгөө эвгүй байдлаас гаргах, тохиолдсон ээдрээтэй үйлд хариу үзүүлэхдээ зерүүлж, зөөлрүүлэн хэлэх, уур бухимдлаа хурдан тайлах, стрессээс хурдан ангижирч чаддаг болно.

8. Хошин шог зохиол бичигчид бараг үгүй болсон гэхэд нэг их буруудахгүй болов уу. Дунд сургуулийн хөтөлбөрт сонгож оруулах зохиол бараг байхгүй болж байгаа нь хүүхдүүдийн хувьд хошин шогийн мэдрэмжийг ном зохиолоос мэдрэх биш аахар шаахар зүйлээс хайдаг болоход хүргэж байна.

²⁰ Ойдов Ч (1972), Түүвэр зохиол, Улаанбаатар, 243-р тал.

SUMMARY

In the article of “Developing students’ humoristic sense with the literature study”, I Intended to express the approaches of creating humor based on the play “A habitual liar” written by Ch.Oidov. This play is being presented to the students in grade 8 and it could be the basic knowledge of learning classical literature of the world for the upper grade students. In order to develop humoristic sense they should acquaint with the approaches of creating humor which are mentioned in comedies. Furthermore it would be essential to use for their writings.

Except hyperbole, exaggeration, sarcasm and irony there are humor of character, gestures and speaking approaches described In the play of “A habitual liar”.

It is said that everyone is able to have abilities of getting rid of unpleasant situations, anger and stress by reading and recognizing the approaches of creating humor. In addition it is useful to acquire an ability to change something unpleasant into positive mood or behavior.